1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ 一般規定

Бусдын итгэлийг олж авах, тэрхүү итгэлийг дааж ажиллах нь дотоод аудиторчуудын нэн чухал зорилт юм. Учир нь аливаа аудит итгэл дээр суурилдаг үйлчилгээ билээ. Энэ зорилтдоо хүрэхийн тулд, мөн түүнчлэн байгууллагын удирдлагыг найдвартай баталгаа, ажил хэрэгч зөвлөгөөгөөр хангахын тулд дотоод аудиторчууд юуны түрүүнд мэргэжлийн хүмүүс хэмээн үнэлэгдэж, хүлээн зөвшөөрөгдөх ёстой. Мэргэжлийн хүмүүс мэргэжлийнхээ стандартыг чанд баримталж ажиллах ёстой. Тэгвэл дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартууд нь дотоод аудитын чанарын баталгаажуулалтад онцгой анхаардаг бөгөөд чанар бол бусдын итгэлийг олж авах гол хүчин зүйл билээ.

内部監査員の非常に重要なことは皆さんの信頼を得ることとその信頼を害しないで持って行くことです。という事は監査は信頼がベースのサービスです。この目標を達成するために、又は上司たちにビジネス助言をするために監査人が何よりもプロの専門家と言う事が推定することが重要です。専門家は基準を守るべきです。すると、内部監査実務国際基準が内部監査品質管理によく注目しています。品質が皆の信頼を受け取る一番重要な要因になります。

Дотоод аудитын чиг үүрэг сүүлийн жилүүдэд өргөжиж дан ганц баталгаажуулах үүргээс гадна зөвлөх үйлчилгээ үзүүлдэг болсон төдийгүй түүний хамрах хүрээ ч зөвхөн дотоод хяналтаар хязгаарлагдахгүй засаглал, эрсдэлийн удирдлагыг хамрах болов. Эрсдэлийн удирдлага болон засаглалын үйл явцыг үнэлэх нь дан ганц хяналтыг үнэлэхээс хавьгүй хэцүү бөгөөд илүү өргөн хүрээтэй. Энэ нь дотоод аудиторыг илүү өндөр, стратегийн түвшинд ажиллахыг шаардах нь ойлгомжтой. Ийм түвшинд ажиллахын тулд, дотоод аудиторчууд сонирхогч талуудын зүгээс илүү өндөр түвшний итгэл хүлээх шаардлагатай болно.

内部監査機能は最近どんどん範囲を広めて、アシュアランスだけじゃなくて、コンサルティングサービスを提供しています。それに内部統制だけではなく、ガバナンスとリスク管理も含まれます。リスク管理とガバナンスの流れを評価するのはコントロールを評価するよりもっと難しくてもっと範囲が広いです。これは、内部監査人がより高い戦略的なレベルで働く必要があります。このレベル働くために、内部監査人は、相手側からもっと信頼を得る必要があります。

Эдгээр хэрэгцээ шаардлагыг хангах цорын ганц арга зам бол байнга ба үе үе хийгдэх дотоод үнэлгээ болон мэргэшсэн хараат бус этгээдээр үе үе хийлгэх хөндлөнгийн үнэлгээ юм.

これらのデマンドを満たすための唯一の方法は、定期的に又は時には行われる内部評価と外部評価です。

2. ЭРХ ЗҮЙН БА СТАНДАРТЫН ШААРДЛАГА 法律や基準

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дүгээр тогтоолоор шинэчилэн батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.5-д “Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчийн дотоод аудитын үйл ажиллагаанд Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд нэг удаа хийнэ” гэж заасан.

モンゴル国内閣の2015年の第483規定で更新された“内部監査規則”の第8条の8.5では“財務省ポートフォリオとその他の予算責任者の内部監査作業にIPPFの通り品質管理評価を2年に1度は実施されると記載してあります。

Дотоод аудиторудын олон улсын институтээс батлан гаргасан “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-ын 1300-т “Аудитын гүйцэтгэх удирдлага дотоод аудитын нэгжийн бүхий л асуудлыг хамарсан чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ёстой” гэж заасан байдаг ба 1312-т “хөндлөнгийн үнэлгээг байгууллагын гаднаас мэргэшсэн, хараат бус үнэлэгч буюу үнэлгээний багаар наад зах нь таван жил тутам хийлгэх ёстой” гэж заасан.

IAによって承認されたIPPFの1300に“監査実施責任者が内部監査部の全問題を含めた品質管理と更新計画を作成し実施するべき”と記載されています。1312に“外部評価を組織外の公認監査人で独立な評価人と評価チームに少なくとも5年ごとに評価してもらわなければならない”と記載されています。

Дээрх стандартын 1321-т “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартуудыг мөрддөг” гэсэн хэллэгийг гагцхүү чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын хөтөлбөрийн үр дүнгээр дэмжигдэж буй нөхцөлд л дотоод аудитын нэгжийн аудитын гүйцэтгэх удирдлага энэхүү хэллэгийг ашиглан мэдэгдэл хийх эрхтэй гэж заасан байдаг.


上記の基準の1321にIPPFを従うという言い言葉を品質管理と改善プログラムの結果によってサポートされてる場合に内部監査部の監査実施責任者がこのいい言葉を使って報告する権利があると記載されています。

3. ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ БА САЙЖРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

品質と改善プログラム

Чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын хөтөлбөр дотоод ба хөндлөнгийн үнэлгээг хамруулсан байх ёстой гэж Стандартын 1310-т заасан байдаг.

品管と改善プログラムは内部と外部評価を含むべきと IPPF の 1310 に記載されています。



Чанарын үнэлгээний үйл явцын дарааллыг дараах дөрвөн хэсэгт хуваан авч үзнэ:

- **Дотоод аудитын засаглал** (Стандарт 1000, 1100, 1300, Ёс зүйн дүрэм болон Дотоод аудитын тодорхойлолт)
- **Дотоод аудитын ажилтнууд** (Стандарт 1200)
- **Дотоод аудитын удирдлага** (Стандарт 2000, 2100, ба 2600)
- **Дотоод аудитын үйл явц** (Стандарт 2200, 2300, 2400, ба 2500)

品官評価プロセス順番を以下の4つの部分に分けます。

- 内部監査ガバナンス (基準 1000、1100、1300、倫理規定や内部監査の定義)
- 内部監査スタッフ (基準 1200)
- 内部監査責任者 (基準 2000、2100、2600)
- 内部監査プロセス (基準 2200、2300、2400、2500)

Хөндлөнгийн үнэлгээ нь бүрэн хөндлөнгийн үнэлгээ буюу хараат бус баталгаа бүхий өөрийн үнэлгээний хэлбэртэй байж болно.

外部評価は、完全な外部評価と独立して保証のある自己評価になります。

Хөндлөнгийн үнэлгээг байгууллагын гаднаас мэргэшсэн, хараат бус хянагч буюу хяналтын багаар наад зах нь таван жил тутам хийлгэх ёстой. Аудитын гүйцэтгэх удирдлага зөвлөлтэй дараах зүйлсийг хэлэлцэх ёстой:

- Хөндлөнгийн үнэлгээг илүү хийлгэх хэрэгцээ шаардлага
- Хөндлөнгийн хянагч буюу хяналтын багийн мэргэшил, хараат бус байдал, түүний дотор аливаа сонирхлын болзошгүй зөрчил.

組織外の独立で公認コントロールチームにしくなくて五年ごとに外部評価をしてもらうべき。監査実施責任者は以下の件で委員会と相談するべきです。

- もっと外部評価をする必要があります。
- 外部コントローラとコントロールチームの公認で独立性と内部の潜在的な利益相反。

Хөндлөнгийн үнэлгээний энэ үйл явцад АГУ болон дотоод аудитын нэгжийн зүгээс цаг зав, хөрөнгө нөөц шаардсан иж бүрэн, бүрэн баримтжуулагдсан өөрийн үнэлгээг эхлээд хийнэ. Дотоод аудитын нэгжийн дотоод өөрийн үнэлгээ болон бэлтгэсэн тайланд мэргэшсэн, хараат бус хөндлөнгийн үнэлгээчин буюу үнэлгээний баг хараат бус баталгаа өгнө. Хараат бус баталгаа бүхий өөрийн үнэлгээнд үр нөлөөтэй ЧБСХ-ийг бүрдүүлэгч баримтжуулалт, үзүүлэлт болон тайлагналыг ашиглана.

外部評価のこのプロセスに監査実施責任者と内部監査部からも時間と予算をかけた完全な評価と完全に文書化した自己評価します。内部監査部の内部の自己評価と、作った報告書に独立で専門の資格を持った外部評価者または評価チームが独立な保証を出します。その独立で保証された自己評価に構成ドキュメンテーション、パフォーマンスおよびレポートを使用します。

Хараат бус баталгаа бүхий өөрийн үнэлгээний хамрах хүрээ нь ОУМПХ-ний заавал мөрдөх удирдамжуудын нийцэлд голлон төвлөрдөг. Дотоод аудитын жижиг нэгжүүд бүрэн хөндлөнгийн үнэлгээ хийлгэхээсээ өмнө хараат бус баталгаа бүхий өөрийн үнэлгээг өөрсдийн анхны хөндлөнгийн үнэлгээ байдлаар хийлгэж болно.

独立して保証された自己評価の範囲はIPPFの拘束的な性格を持つガイダンスのコンプライアンスに一番集中します。内部監査部門の完全な外部評価をしてもらう前に独立でアシュアランス自己評価を初めての外部評価する事はできます。

Бүрэн хөндлөнгийн үнэлгээг мэргэшсэн, хараат бус хөндлөнгийн үнэлгээчин буюу үнэлгээний баг хийх бөгөөд ингэхдээ төслийн туршлагатай, мэргэжлийн менежерийн удирдлагын дор гадны чадварлаг мэргэжилтнүүдийн баг ажиллуулна. АГУ бүрэн

хөндлөнгийн үнэлгээний арга хандлагыг тодорхойлохдоо гүйцэтгэх удирдлага ба зөвлөлийн саналыг авдаг бөгөөд энэ нь ОУМПХ-ний заавал мөрдөх удирдамжуудын нийцлээс илүү өргөн хүрээг ихэвчлэн хамардаг

完全外部評価を専門職的、独立な外部評価者と評価チームが実施します。そうすることでプロジェクトのよく経験があるプロのマネージャーの指導の下で組織外のチームが実施します。

監査実施責任者は完全な外部評価実施方法について結論出す時、実施責任者と委員会の意見をうけます。これが IPPF の拘束的な性格を持つガイダンスのコンプライアンスより広い範囲を含めてます。

ЧБСХ нь дараах нийтлэг элементийг агуулна: 品管改善プログラムは、次のような共通の要素が含まれています。

- ・ Дотоод аудитын нэгжийн бүхий л асуудал.
- ・ Дотоод аудитын тодорхойлолт, Ёс зүйн дүрэм болон ДАИ-ийн *Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартууд (Стандартууд)*-д нийцэх байдлыг үнэлэх.
- ・ Дотоод аудитын нэгжийн үр ашиг, үр нөлөөг үнэлэх.
- ・ Сайжруулах боломжуудыг олж тогтоох.

・内部監査部門の諸問題

・内部監査の定義、倫理綱要と IIA の内部監査の専門職的实施の国際基準に適合性を評価します。

・内部監査部門の効率性と有効性を評価します。


・改善の機会を特定。

ДАИ-ийн “Чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын хөтөлбөр” хэмээх практик зааварт засаглал, мэргэжлийн практик, мэдээлэл харилцааг хамарсан хөтөлбөрт-суурилсан хүрээг тодорхойлж өгсөн. Зураг 2.1-г үзнэ үү. Энэхүү хүрээ нь зөвхөн удирдамжийн зориулалттай. АГУ *Стандартуудад* нийцүүлэн ЧБСХ-ийн өөрийн загварыг боловсруулж болно.

IIA の品質管理改善プログラムという実務的なガイドガバナンスと専門職実務、およびコミュニケーション関係含めたプログラムベースのフレームワークを明記した。図 2.1 を参照してください。この範囲は、唯一の指導のためです。監査実施責任者 基準に合わせて、品管改善プログラムの独自のモデルを開発することができます。

4. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЙЛ ЯВЦ 品質評価プロセス

ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГ



5. УЛСЫН САЛБАРТ ДОТООД АУДИТЫН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ ТОГТОЛЦООНЫ САНАЛ

5.1 政府セクターに内部監査品質管理する制度の提案

Чанарын баталгаажуулалт хийх бүтэц зохион байгуулалт 品質管理の組織

Төсвийн тухай хуулийн 69-р зүйлд “Сангийн яам нь дотоод аудитыг удирдлага арга зүйгээр хангаж ажиллана” хэмээн заасан байдаг тул дотоод аудитын үйл ажиллагааны чанар, найдвартай байдлыг хангах нэг гол тогтолцоо болох чанарын баталгаажуулалтын хөндлөнгийн үнэлгээг Сангийн яам хариуцан хийх нь зүйтэй юм. 予算法の 69 条によると、「財務省は、内部監査を指導をする」と記載してあります。

内部監査業務品質、信頼性である制度は品質管理外部評価を財務省が担当になるのは適切です。

Бусад чиглэлийн яамд өөрийн дотоод үнэлгээ болон хөндлөнгийн хараат бус үнэлгээний багаар баталгаажуулсан өөрийн үнэлгээг тогтмол хийх ба “Дотоод аудитын тухай хууль”(хуулийн төсөлд тусгагдсан) болон Олон Улсын мэргэжлийн практикийн хүрээнд заасан хугацаанд Сангийн яамнаас чанарын баталгаажуулалтын хөндлөнгийн үнэлгээ хийн, дотоод аудитын үр нөлөөг сайжруулах, стандарт, тодорхойлолтод нийцэх байдлыг тодорхойлж ажиллах шаардлагатай юм.


他の省庁は、内部自己評価と独立した外部評価チームに保証された自己評価を定期的に行い、「内部監査法」（法案が含まれている）と IPPF に記載されてる期間中に財務省から品質管理外部評価をし、内部監査の実効性を改善し、基準と定義に合う状況を表していく必要があります。

Чиглэлийн яамдаас тогтмол хугацаанд хийгдэх дотоод үнэлгээ болон, хараат бус хөндлөнгийн үнэлгээчээр баталгаажуулсан өөрийн үнэлгээний үр дүнг Сангийн яаманд хүргүүлж, эдгээр үнэлгээний тайланд дүн шинжилгээ хийх замаар Сангийн яамнаас хийх хөндлөнгийн үнэлгээнд хамруулах байгууллага, аудитын ажлыг сонгоно.

省庁は定期的に行う内部評価と独立した外部評価者に保証された自公評価の結果を財務省に提出し、評価報告書に分析する形で財務省が行う外部評価組織と監査業務を選択する。

Чиглэлийн яамд өөрийн харьяа нэгжүүдэд дотоод аудитын чанарын баталгаажуулалтын хөндлөнгийн үнэлгээг хийнэ. Харьяа нэгжүүдийн хувьд дотоод үнэлгээг өөрсдийн хэмжээнд тогтмол хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай.

省庁は、各実施機関に監査品管の外部評価をする。実施機関に対して内部評価を定期的に行うべき。



5.2 Хүний нөөц, төсөв 人材・予算

Сангийн яамны СХЭУГ нь дотоод аудитыг удирдлага арга зүйгээр хангах, Сангийн яамны дотоод аудитыг хариуцан хийх чиг үүргийнхээ хүрээнд

- ・ Сургалт, арга зүй хариуцсан ажилтан
- ・ Дотоод аудитын чанарын баталгаажуулалт хариуцсан ажилтан
- ・ Дотоод аудит хариуцсан ажилтнуудтай байх нь зүйтэй.

財務省のBCRM局が、内部監査を指導する、財務省の内部監査担当する

- ・研修とガイダンス担当者
- ・内部監査品質管理担当者
- ・内部監査担当者がいることが適切です。

Шинээр хүний нөөц болон холбогдох төсөв шаардлагагүйгээр ажлын байрны тодорхойлолтод чанарын баталгаажуулалтын чиг үүргийг нэмснээр шийдвэрлэх боломжтой. Сангийн яамны чанарын баталгаажуулалт хариуцсан ажилтан нь бодитой хандлага алдагдуулахгүй байх шаардлагын үүднээс чиглэлийн яамдтай хамтран гүйцэтгэх тусгай аудитын багт оролцохгүй байх, Сангийн яамны дотоод чанарын баталгаажуулалтын үнэлгээ хийх шаардлагын үүднээс дотоод аудитад оролцохгүй байх нь зүйтэй. Сангийн яамны Чанарын баталгаажуулалт хариуцсан ажилтан нь

新たに人材や予算を追加せずに、品管を職務内容に追加して解決できることが可能です。財務省の品管担当者は客観性。客観性を維持する事が重要のため省庁と協力して実施す

るチームに参加しない、財務省の内部評価をするため内部監査にも参加しないことが適切である。財務省の品管担当者は：

- ・ Дотоод аудитын практик болон онолын мэдлэг сайтай
- ・ Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ болон хөндлөнгийн үнэлгээний гарын авлагын агуулгад мэргэшсэн
- ・ Дотоод аудитын хууль эрх зүйн орчны талаарх мэдлэг сайтай
- ・ Дотоод аудитын нэгдсэн мэдээллийн сүлжээний орчинд ажиллах чадвартай
- ・ Харилцааны болон ёс зүйн өндөр түвшинтэй байх шаардлагатай.
- ・ Заах аргын ур чадвар сайтай байх.
 - ・ 内部監査実務と理論的な知識がある
 - ・ IPPF と外部評価のマニュアルの内容に詳しい
 - ・ 内部監査法の知識が高い
 - ・ 内部監査のサーバーネットワーク環境の中に仕事できる
 - ・ コミュニケーションの能力がある事と高いレベルの倫理がある事が必要です。

Сангийн яамны дотоод аудитын чанарын баталгаажуулалтын үнэлгээ хариуцсан ажилтан нь бусад яамдын тухайн чиг үүрэг хүлээсэн ажилтнуудыг удирдлага арга зүйгээр хангаж ажиллах шаардлагын үүднээс заах аргын болон харилцааны ур чадвартай байх шаардлага тулгарна. 財務省の内部監査品管評価担当が他の省庁の当担当者に対して指導する必要があるため教授方法とコミュニケーションの能力があることが大切です。

Хариуцсан ажилтнаас хамааралтай байхгүйн тулд өөрийн гүйцэтгэсэн аудит дээр чанарын үнэлгээ хийхгүй гэсэн шаардлагад нийцүүлэн, газрын ажилтнууд тодорхой хугацаагаар сэлгэн энэхүү чиг үүргийг гүйцэтгэх боломжтой. 当担当者に依存しないため自分の実施した監査に品管評価をしないという必要に合わせ、局のスタッフをある程度の期間に切り替え、この指導を実施する事が可能です。

Дотоод үнэлгээний тухайд, тогтмол хугацаанд тогсон шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурлан дотоод аудитын гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийх (хяналт шинжилгээ хариуцсан ажилтан, эсвэл дотоод аудитын талаар мэдлэгтэй яамны өөр ажилтнаар хийлгэх) байдлаар хяналт тавих боломжтой. 内部評価に対して、定期的に決まった条件に基づき内部監査実施にモニタリングする（モニタリング担当者、あるいは内部監査について知識が高い別の職員にさせる）形でコントロールする事が可能です。

Практик зааврууд (Чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын хөтөлбөр, Стандартуудыг хэрэгжүүлэх, Дотоод аудитын үр ашиг, үр нөлөөг хэмжихэд нь дотоод аудитын жижиг нэгжүүдэд туслах)-аас авч ашигласан. Дотоод аудитын нэгжийг тасралгүй сайжруулах болон таван жил тугам чанарын хөндлөнгийн үнэлгээ хийлгэхэд бэлтгэхэд нь туслах байнгын ба үе үе хийгдэх дотоод үнэлгээ хийх хөтөлбөрийн товч тоймыг энд мөн оруулсан.

2 章では、品質評価のマニュアルの別の目的は効果的な品管改善プログラムがあることは内部監査部門を品質外部評価準備にどれくらい役に立つか検討した。又は、IIAの実務説明（品管と改善プログラム、基準実施、内部監査効率化を図るために内部監査部門が協力する）を使った。内部監査部門を改善し5年度に品質外部評価する準備に役に立つ定期的と時々内部評価プログラムの一覧も入れている。

Гуравдугаар бүлэгт хараат бус хөндлөнгийн баталгаа бүхий өөрийн үнэлгээ хэмээх хөндлөнгийн үнэлгээний хэлбэрийг авч үзсэн. Хөндлөнгийн үнэлгээний энэ үйл явцад АГУ болон дотоод аудитын нэгжийн зүгээс цаг зав, хөрөнгө нөөц шаардсан иж бүрэн, бүрэн баримтжуулагдсан өөрийн үнэлгээг эхлээд хийнэ. Дотоод аудитын нэгжийн дотоод өөрийн үнэлгээ болон бэлтгэсэн тайланд мэргэшсэн, хараат бус хөндлөнгийн үнэлгээчин буюу үнэлгээний баг хараат бус баталгаа өгнө. Хараат бус баталгаа бүхий өөрийн үнэлгээнд үр нөлөөтэй ЧБСХ-ийг бүрдүүлэгч баримтжуулалт, үзүүлэлт болон тайлагналыг ашиглана. 3 章では、独立で外部保証がある自己評価という外部評価の形を見てみました。外部評価のこのプロセスに監査実施責任者と内部監査部門が時間と予算をかけた完全な完全に証拠した自己評価を先にする。内部監査部門の内部自己評価や報告案にプロの独立した外部評価者と評価チームが独立的な保証を出す。独立な保証がある自己評価には効率な品管改善プログラムの一部になる証拠、指標や報告書を使用する。

Хараат бус баталгаа бүхий өөрийн үнэлгээний хамрах хүрээ нь ОУМПХ-ний заавал мөрдөх удирдамжуудын нийцэлд голлон төвлөрдөг. Дотоод аудитын жижиг нэгжүүд бүрэн хөндлөнгийн үнэлгээ хийлгэхээсээ өмнө хараат бус баталгаа бүхий өөрийн үнэлгээг өөрсдийн анхны хөндлөнгийн үнэлгээ байдлаар хийлгэж болно.

独立で保証がある自公評価の範囲がIPPFの拘束的な性格を持つガイダンスのコンプライアンスに集中している。内部監査部門が完全に外部評価される前に独立で保証がある自己評価を最終外部評価でする事ができます。

Дөрөвдүгээр бүлэгт бүрэн хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явцыг тоймлон тайлбарласан бөгөөд энэ нь дотоод аудитын нэгжийн ЧБСХ-ийн тулгын чулуу хэмээн тооцогддог. Бүрэн хөндлөнгийн үнэлгээг мэргэшсэн, хараат бус хөндлөнгийн үнэлгээчин буюу үнэлгээний баг хийх бөгөөд ингэхдээ төслийн туршлагатай, мэргэжлийн менежерийн удирдлагын дор гадны чадварлаг мэргэжилтнүүдийн баг

ажиллуулна. АГУ бүрэн хөндлөнгийн үнэлгээний арга хандлагыг тодорхойлохдоо гүйцэтгэх удирдлага ба зөвлөлийн саналыг авдаг бөгөөд энэ нь ОУМПХ-ний заавал мөрдөх удирдамжуудын нийцлээс илүү өргөн хүрээг ихэвчлэн хамардаг. 4 章では、完全な外部評価をするプロセスを概要に説明し、これが内部監査部門の品質改善プログラムのベースと考えられる。プロの独立した外部評価者と評価チームが完全な外部評価をし、プロジェクトの経験があるプロのマネージャの指導で外国の専門家のチームが働きます。監査実施責任者が完全な外部評価の方法を定義すると監査実施責任者と、協議会の提案を受け、これが IPPF 拘束的な性格を持つガイダンスのコンプライアンスより広い範囲です。

Бүлгүүдийн ард чанарын үнэлгээ хийх арга хэрэгслүүдийг хавсаргасан. Тэдгээрт тухайн арга хэрэгслийг хэрхэн ашиглах заавар болон Чанарын үнэлгээний үйл явцын холбогдох арга хэрэгслийг тодруулан харуулсан зураг оруулсан.

Дотоод үнэлгээнд зориулсан гарын авлагыг боловсруулах ажил хийгдээгүй байгаа ба Сангийн яамнаас Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төслийн дараагийн шатны хүсэлтэд энэ талаар тусгагдан төлөвлөгдсөн байгаа болно.

各章に品質評価するツールを添付した。それらに当ツールを使用するための説明と品質評価プロセスに関連するツールを明らかに表示した図を添付した。

内部評価のためのマニュアルはまだ作成されていない。財務省から JICA と協力して実施しているプロジェクトの次の段階にこれについて計画されています。

Internal Audit Quality Assurance Framework

1. Background

One of the audit's major assets is its credibility with stakeholders. To provide credible assistance and constructive challenge to management, internal auditors must be perceived as professionals. Professionalism requires conforming to a set of professional standards. The IIA's IPPF (Standards) explains how they have evolved as profession has matured and how their application should be tailored to each organization without compromising conformance with the Standards.

Internal audit functions expanded in recent years from single assurance service but also provides consulting services, and also its scope become cover governance and risk management, not limited only to internal control. It is much harder to assess risk management and governance process than assessing single control. This will require internal auditor to work more strategic level. To work such high level, the internal auditors shall have a high level credibility from stakeholders.

The only way to meet these needs is continuous and frequent internal assessment and also periodic external assessment done by qualified independent external body.

2. LEGAL AND STANDARD REQUIREMENT


It is referred to as "State administrative body in charge of Finance and Budget shall execute quality assurance to Portfolio governor and Fiscal governor activities once in 2 years, in accordance with IPPF" in 8.5 of the Article 8 of the "Internal Audit Charter" adopted and revised by the 483th Mongolian Government Resolution on 2015.

Standard 1300 of IPPF, which issued by IIA is defined as "The Chief audit executive must develop and maintain a quality assurance and improvement program that covers all aspects of the internal audit activity" and also standard 1312 states as "External assessment must be conducted at least once every five years by qualified, independent assessor or assessment team from outside the organization."

Standard 1321 of the above mentioned IPPF defines use of "Conforms with the International Standards for the Professional Practice of Internal Auditing" as "The Chief audit executive may state that the internal audit activity conforms with the International Standards for the Professional Practice of International Auditing only if the results of the quality assurance and improvement program support this statement".

3. QUALITY ASSURANCE AND IMPROVEMENT PROGRAM (QAIP)

The quality assurance and improvement program must include both internal and external assessment. (IPPF 1310)



Quality assessment process flow should be divided into four segments:

- **Internal audit governance** (Standard 1000, 1100, 1300, Code of Ethics, and the Definition of Internal Auditing)
- **Internal audit staffs** (Standard 1200)
- **Internal audit management** (Standard 2000, 2100, 2600)
- **Internal Audit Process** (Standard 2200, 2300, 2400, 2500)

External assessment can be in the form of full external assessment and self-assessment with independent validation.

External assessment must be conducted at least once every five years by a qualified, independent assessor or assessment team from outside the organization. The chief audit executive must discuss with the board:

- The form and frequency of external assessments;
- The qualification and independence of the external assessor or assessment team, including any potential conflict of interest.

At the beginning of the external assessment process CAE and internal audit unit should execute fully evidenced self-assessment which needs time and budget. Qualified external assessor and independent external assessment team should validate the self-assessment and prepared report.

A self-assessment with independent external validation includes a comprehensive and fully documented self-assessment process that requires the chief audit executive (CAE) to complete the self-assessment work, and normally provides limited attention to benchmarking, review and consultation as to implementation of leading practices.

The full external assessment process involves the chief audit executive (CAE) acquiring a suitable independent, qualified provider of external assessment services, as guided by the Standards. The CAE should provide input into the requested scope of the full external assessment and its specific objectives. This process should also ensure full consideration regarding expectations of executive management and the audit committee.


Common elements of all QAIPs include:

- All facets of the internal audit activity.
- An evaluation of conformance with the Definition of Internal Auditing, the Code of Ethics, and The IIA's International Standards for the Professional Practice of Internal Auditing (Standards)
- An appraisal of the efficiency and effectiveness of the internal audit activity.
- Identification of opportunities for improvement

A framework is the complete environment for developing and implementing the QAIP. IIA Practice Guide, Quality assurance and improvement program, has documented a program-based framework consisting of governance, professional practice, and communication. This framework is intended as guidance only. CAEs may develop their own QAIP structure in conformance with the Standards.

4. QUALITY ASSESSMENT PROCESS MAP

QUALITY ASSESSMENT PROCESS MAP



5. PROPOSAL FOR EXECUTING INTERNAL AUDIT QUALITY ASSURANCE IN PUBLIC SECTOR


5.1 Executing Structure of Quality Assurance

According to the Article 69 of the Budget law, "Ministry of Finance (hereinafter referred to as "MOF"), shall provide instruction and guidance to internal audit activities, thus the Ministry of Finance will be responsible for quality assurance external evaluation, which is a key system to ensure the quality of the internal audit function and its reliability.

Other line ministries to do internal evaluation and regular self-assessments approved by external independent external evaluation regularly, and execute external evaluation in the period specified in the "Internal audit draft bill" and IPPF by the MOF for improving the effectiveness of internal audit and determining compliance with the standards and specifications.

Line ministries should submit the results of the internal evaluation and self-assessments, approved by independent external evaluation to the MOF. Ministry of Finance will analyse the results and determine the organization, which should be selected to the external evaluation by MOF.

Line Ministries should execute an independent quality assurance external evaluation to its affiliated implementing Agencies. Implementing agencies should execute its internal evaluations periodically by their own.



5.2 Human resources and budget

Financial Control and Risk Management Department (hereinafter referred to as “FC-RM”) under the Ministry of Finance is responsible for providing guidance to other Line Ministries and also has function to implement internal auditing within the Ministry. Thus the Department have has the following officers:

- Officer, responsible for Training and Methodology
- Officer, responsible for Internal audit quality assurance
- Officer, responsible for Internal audit

Adding quality assurance functions to job description is the solving way, which not need additional human resources and related budgets.

Quality assurance officer of the Ministry of Finance shall not involved in Internal audit team, which execute internal audit with other Line ministries for meeting the requirement on objectivity disturbing and also should not participate internal audit activities of MOF, because of executing internal quality assurance evaluation of the ministry. Officer, responsible for Quality Assurance should have the following knowledge and skills:

- Good Theoretical and Practical Knowledge and Skill on Internal Audit
- Good knowledge on IPPF and Quality assurance manual
- Good knowledge on internal audit related legal acts
- Good skill working on Internal audit information data system
- Good communication skill and have high ethics of Internal auditor
- Good skill of teaching others

Officer in charge of Internal audit quality assurance assessment of the Ministry of Finance should have teaching and communication skill to ensure that to instruct staffs of the other line ministries.

In order not to depend on the person responsible for the quality assurance, if satisfying of the requirement that not doing quality assessment on its own performed audit, officers of the department are possible to perform these functions by switching particular period of time.

Regarding internal evaluation, it is possible to monitor (monitoring officer or another staff of the ministry, who has knowledge on internal audit) periodically internal audit performance based on indicators.

5.3 Tools

Quality Assessment Manual was developed based on Manual for Quality Assurance of the Internal Audit Unit, which has published by Institute of Internal Auditors Research Foundation (IIARF) on 2013.

Overall objective was to produce a set of tools that will streamline the process for gathering evidence and performing a quality assessment. This required creating a process flow to ensure data used by multiple tools is collected only once and designing new tools to confirm any duplication of work is eliminated. Tools format and methodology were standardized to promote ease of use while achieving consistency in assessment techniques and documentation of results. The new process should result in a quality assessment workflow that naturally progresses from information collection and analysis through completion of the assessment, identification of issues and opportunities, and preparation of the final report.

Chapter 1 provides an overview of quality assurance within the practice of internal auditing, which was evolved from primary focus on internal control to include governance and risk management. In this chapter, key elements of IPPF is included, which form the foundation for establishing quality assurance, noting that practices must be adapted to the legal and cultural environment, size of the organization supported by the internal audit activity.

Chapter 2 addresses another key objective for the quality manual: to provide specific direction regarding how maintaining an effective QAIP will help an internal audit activity prepare for external quality assessment.

Developed the chapter on establishing effective QAIP by considering guidance from recently published IIA Practice Guides: Quality assurance and improvement program, Assisting Small Internal audit activities in implementing the Standards, and Measuring Internal Audit Efficiency and Effectiveness. Included is an outline of a program to perform ongoing and periodic internal assessment that will support continuous improvement and prepare an internal audit activity for an external quality assessment every five years.

Chapter 3 describes external assessment achieved through self-assessment with independent external validation. This process involves a comprehensive, fully documented self-assessment requiring time and resource commitments on the part of the CAE and the internal audit activity. A qualified independent external assessor or assessment team conducts an independent validation of the self-assessment and the report prepared by the internal audit activity. A successful self-assessment with independent validation will leverage the documentation, metrics, and reporting that comprise an effective QAIP.

The scope of a self-assessment with independent validation primarily focuses on conformance with the mandatory guidance of the IPPF. Many smaller internal activities

conduct self-assessment with independent validation as their initial external assessment before moving on to a full external assessment.

Chapter 4 outlines the process for conducting a full external assessment, which many practitioners regard as the capstone of an internal audit activity's QAIP. The full external assessment is conducted by a qualified, independent external assessor or assessment team. The CAE involves senior management and the board in determining the approach for a full external assessment, which typically consists of a broad scope of coverage beyond conformance with the mandatory guidance of the IPPF.

Appendices following the chapters contain the tools we developed to perform a quality assessment. Each tool's appendix includes guidance on how to use the tool and a copy of the Quality Assessment Process Map, which highlights the relevant tools being discussed.

Manual for Internal assessment is not developed. It is included and planned to implement in the next Phase of the Project, of which Request for implementation was submitted to the Japanese Government from Mongolian Government.

Дотоод аудитыг хөгжүүлэх дунд
хугацааны стратеги төлөвлөгөө
(2017-2020)

Сангийн яам

2016 оны 12 сар

ӨМНӨХ ҮГ

Сангийн сайд Б.Чойжилсүрэн

Сангийн сайдын 2016 оны ...тушаалын 1-р хавсралт

УЛСЫН САЛБАРЫН ДОТООД АУДИТЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ

Нэг. Нийтлэг үндэслэл


Монгол Улсад төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцооны эхлэл Төсвийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, өргө хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж зааснаар болон тус хуулийн 69.5 дахь хэсгийг үндэслэн, Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор “Дотоод аудитын дүрэм” батлагдсанаар анх тавигдсан болно. Энэхүү дүрмийг 2015 онд Засгийн газрын тогтоолоор шинэчилэн баталж дотоод аудитын хүрээнд хийгдэх санхүүгийн хяналт шалгалтын чиг үүргийг тодорхой болгосон. Төсвийн тухай хууль, дотоод аудитын дүрмийн хүрээнд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дотоод аудитын үйл ажиллагааг арга зүйн удирдлагаар хангаж ажиллах үүрэг хүлээсэн бөгөөд улсын салбарын дотоод аудитыг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх, төрийн зөв, зохистой дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг эрсдэлээс сэргийлэх, засаглалыг бэхжүүлэх зорилго нь “Улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг боловсруулах үндэслэл болно.

Хоёр. Стратегийн үндсэн зорилго, зорилт

2.1 Стратегийн зорилго

“Улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн зорилго нь дотоод аудитын эрх зүйн орчин, тогтолцоог боловсронгуй болгох, дотоод аудиторын практик ур чадварыг бэхжүүлэх, дотоод аудитыг мэргэжлийн өндөр түвшинд чанарын шалгуурт нийцүүлэн хэрэгжүүлэхэд оршино.

2.2 Стратегийн зорилгыг дараах зорилтуудаар дамжуулан хэрэгжүүлнэ.



Гурав. Стратегийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

- 3.1 Сангийн яам нь улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төв ба орон нутгийн төрийн байгууллагуудыг удирдлага арга зүйгээр хангаж ажиллана.
- 3.2 Стратегийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах шаардлагатай зардлыг улсын ба орон нутгийн төсөвт тусгаж ажиллана.
- 3.3 Хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг бүх шатны төрийн байгууллагын удирдлага, дотоод аудит хариуцсан ажилтнууд болон дотоод аудитад хамрагдах нэгжүүд хүлээнэ.
- 3.4 Стратегийн агуулга, чиглэлд өөрчлөлт оруулахаар бол холбогдох байгууллагууд санал гарган нийтээр хэлэлцэж шийдвэрлэнэ.

Дөрөв. Стратегийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

- 4.1 Дотоод аудитын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:
 - 4.1.1 Улсын салбарын дотоод аудитын тухай хуулийн төслийг өргөн мэдүүлж, батлуулах
 - 4.1.2 Батлагдсан дотоод аудитын хуультай нийцүүлэн, дотоод аудитын үйл ажиллагаанд шаардлагатай эрх зүйн актуудыг боловсруулж, батлуулах.
- 4.2 Бүтэц зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох

- 4.2.1 Дотоод аудитын хуулийн заалтад нийцүүлэн дотоод аудитын нэгж, дотоод аудитын хорооны бүтцийг бүрдүүлэх
 - 4.2.2 Дотоод аудиторын томилгооны болон тайлагналтын тогтолцоог бүрдүүлэх
 - 4.2.3 Дотоод аудитын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, дотоод аудитын нэгдсэн удирдлагаар хангах боломжоор хангах.
- 4.3 Дотоод аудитуудын практик чадавхийг сайжруулах
- 4.3.1 Улсын салбарын дотоод аудитор бэлтгэх нэгдсэн сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтын аль хэсгийг хуулийн заалтын дагуу мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, аль хэсгийг Сангийн яам Төсвийн тухай хуулийн хүрээнд хүлээсэн үүргийн дагуу хэрэгжүүлэхийг тодорхой болгох.
 - 4.3.2 Улсын салбарын дотоод аудитын нэгдсэн мэдээллийн системд дотоод аудитуудын сургалтанд хамрагдалтын талаарх мэдээллийг тусгадаг болох, энэхүү мэдээллийг хүний нөөцийн үнэлгээний тогтолцоотой уялдуулж ажлын гүйцэтгэл үр дүнгийн үнэлгээнд тусгадаг болгох.
 - 4.3.3 Сургалт болон дотоод аудит хийхэд шаардлагатай арга зүйн баримт бичиг, гарын авлага материал, олон улсын мэргэжлийн практик хүрээ (IPPF)-ний шинэчилэлтийг оруулан боловсруулж дуусгах. Дотоод аудитад ашиглан, шинэчилэн сайжруулалт хийх.
- 4.4 Дотоод аудитын чанарыг нэгдсэн түвшинд хүргэх
- 4.4.1 Дотоод аудитын чанарын баталгаажуулалтын үнэлгээний журам боловсруулж батлуулах.
 - 4.4.2 Дотоод аудитын чанарын баталгаажуулалтын хөндлөнгийн үнэлгээний хөтөлбөр боловсруулж, боловсруулсан дотоод аудитын хөндлөнгийн үнэлгээний гарын авлагыг ашиглан хэрэгжүүлнэ. Хөндлөнгийн үнэлгээний гарын авлагын шинэчилэлт сайжруулалтыг хийнэ.
 - 4.4.3 Чанарын баталгаажуулалтын мэдээллийн сан байгуулж, дотоод аудитын мэдээллийг нэгтгэн оруулах, мэдээллийн системд ирсэн аудитын үр дүнд чанарын үнэлгээ хийх тогтолцоо бүрдүүлэх.
 - 4.4.4 Чанарын баталгаажуулалтын дотоод үнэлгээний тогтолцоо бүрдүүлж, шаардлагатай гарын авлага материал боловсруулах, дотоод үнэлгээний үр дүнг хүний нөөцийн ажлын гүйцэтгэлийн үр дүнд тусгадаг тогтолцоог бүрдүүлэх.

**УЛСЫН САЛБАРЫН ДОТООД АУДИТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ДУНД
ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2017-2020 ОН)**

Зорилт	Стратеги	Хэрэгжүүлэх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа	Төсөв
Стратеги зорилт 1 Эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Стратеги 1.1 Дотоод аудитын тухай хууль, дагалдаж гарах дүрэм, аргачилалыг боловсруулж, батлууна	1.1.1 Хуулийн төслийг өргөн мэдүүлж батлуулах 1.1.2 Хуулийг таниулан, сурталчилах үйл ажиллагааг улс даяар хийх	Сангийн яам Хууль зүйн яам	2017 он 6 сарын 25-ны өдөр хүртэл	Хууль таниулах ажилд 30 хүн/сар
	Стратеги 1.2 Хуульд нийцсэн үйл ажиллагааны журмуудыг боловсруулж, батлуулах	1.2.1 Дотоод аудитын үлгэрчилсэн дүрмийг хуульд нийцүүлэн шинэчилэн найруулж, батлуулах 1.2.2 Дотоод аудитын хорооны үлгэрчилсэн дүрмийн шинэчилсэн найруулгыг хийж, батлуулах			
	Стратеги 1.3 Дотоод аудитын үйл ажиллагаанд шаардлагатай эрх зүйн актуудыг боловсронгуй болгох	1.3.1 Дотоод аудиторын ёс зүйн дүрэм боловсруулж батлуулах 1.3.2 Дундын дотоод аудитын нэгж байгуулан ажиллахтай холбоотой зохицуулалтын журмыг боловсруулж батлуулах			
Стратеги зорилт 2 Бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох	Стратеги 2.1 Дотоод аудитын нэгжийг зохих түвшинд байгуулах	2.1.1 Дотоод аудит болон хяналт, шинжилгээ- үнэлгээ, мониторингийн бүтцийг өөрчлөн зохион байгуулах 2.1.2 Нэгжийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх	Сангийн яам Салбарын яамд ТЕЗ		
	Стратеги 2.2 Дотоод аудитын үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг дээшлүүлэх	2.2.1 Дотоод аудитын хороодыг хуульд заасан бүтцийн дагуу шинэчилэн байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах 2.2.2 Дотоод аудитын тайлагналтын тогтолцоог бүрдүүлэх 2.2.3 Дотоод аудиторын томилгооны тогтолцоог бүрдүүлэх 2.2.4 Дотоод аудитор авлига, зөрчилд өртөхөөс сэргийлсэн цалин урамшууллын зохистой тогтолцоог бүрдүүлэх		2017 он 6 сарын 25-ны өдөр хүртэл	

	Стратеги 2.3 Дотоод аудитын хүрээнд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах тогтолцоог бэхжүүлэх	2.3.1 Төрийн ба орон нутгийн байгууллагуудын дотоод аудитын нэгдсэн сүлжээг бүрдүүлэх 2.3.2 Улс даяар хийгдсэн дотоод аудитын талаарх мэдээллийг бүртгэн, нэгтгэх мэдээллийн сан байгуулах	Сангийн яам	2017-2018 оны 12 сар	Сервер 100 сая төгрөг
Стратеги зорилт 3 Дотоод аудитуудын практик чадавхийг сайжруулах	Стратеги 3.1: Дотоод аудиторын практик чадавхийг сайжруулах тогтолцоог бүрдүүлэх	3.1.1 Мэргэжлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөө боловсруулах	Сангийн яам Салбарын яамд ТЕЗ		
		3.1.2 Улсын салбарын дотоод аудиторын мэргэжлийн сургалтыг хэрэгжүүлэх төрийн бус байгууллагыг холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулна.			
		3.1.3 Улсын салбарын ажилтнуудад зориулсан дотоод аудитын сургалт зохион байгуулах			
		3.1.4 Улсын салбарын удирдах албан тушаалтнуудад зориулсан дотоод аудитын сургалт зохион байгуулах			
		3.1.5 Улсын салбарын дотоод аудитын зааварлагч бэлтгэх сургалт зохион байгуулах			
		3.1.6 Улсын салбарын дотоод аудиторын мэдээллийн сан бүрдүүлэх			
		3.1.7 Улсын салбарын дотоод аудиторуудын туршлага солилцох уулзалтыг тогтмол зохион байгуулах			
	Стратеги 3.2 : Гарын авлага материал	3.2.1 Улсын салбарын дотоод аудитын гарын авлагын шинэчилсэн хувилбарыг боловсруулах	Сангийн яам	2017/06 сар	Хэвлэн олшруулах зардал тусгах
3.2.3 Улсын салбарын дотоод аудитын нэгдсэн системийн ашиглалтын гарын авлага боловсруулах. Сургалт хийх.					

		3.2.4 Олон улсын мэргэжлийн практикийн хүрээний шинэчилэлтийг холбогдох байгууллагатай хамтран орчуулж, дотоод аудиторуудад таниулах			Орчуулгын ба хэвлэлийн зардал гарна.
Стратеги зорилт 4 Дотоод аудитын чанарыг нэгдсэн түвшинд хүргэх	Стратеги 4.1: Чанарын баталгаажуулалтын хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх	4.1.1 Чанарын баталгаажуулалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх			
		4.1.2 Чанарын баталгаажуулалтын хөндлөнгийн үнэлгээний гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах			
		4.1.3 Дотоод аудитын чанарын баталгаажуулалтын үнэлгээний журам боловсруулж, батлуулах			
		4.1.4 Дотоод аудитын хөндлөнгийн үнэлгээний мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд тусгах			
	Стратеги 4.2: Чанарын баталгаажуулалтын дотоод үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх	4.2.1 Чанарын баталгаажуулалтын дотоод үнэлгээний гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах		2018.01.01-2018.12.31	
		4.2.2 Дотоод үнэлгээний журам боловсруулах			
		4.2.3 Дотоод үнэлгээний төлөвлөгөө боловсруулах			
		4.2.4 Дотоод үнэлгээний үр дүнг хүний нөөцийн ажлын үнэлгээтэй уялдуулах тогтолцоог бүрдүүлэх			

内部監査中期戦略計画（2017-2020）

大蔵省

2016年12月

前書

大蔵大臣 B.Choijilsuren

大蔵大臣の 2016 年度の...号通達の添付①


政府部門内部監査中期戦略**一. 総則**

モンゴル国政府部門内部監査制度の起点は、予算法の第 69 条 69.1 に「各予算統括管理者が法律の実施状況の監督、予算、負債、収支、各種プログラム、投資資金に対する財務検査を実施し、結果について評価及び助言を行い、リスクマネジメントを展開した内部監査局を設置し、内部監査人を雇う」という定めと、本法の第 69.5 に基づいて、内閣 2012 年 29 号決議によって制定された「内部監査規程」が承認された時である。本内部監査規程が 2015 年に内閣の決議で更新され、内部監査の一環としての財務検査機能を新たに導入した。予算法、内部監査規程において財務・予算を担当する行政中央機関が内部監査業務の技術指導をする立場になっており、政府部門の内部監査を国際基準に沿って発展させ、適切な内部統制制度を構築し、公共サービス、業務活動へのリスク削減、ガバナンスを強化させるという目標は「政府部門の内部監査中期戦略」を作成する根拠となる。

二. 戦略目的、目標**2.1 戦略目的**

「政府部門の内部監査中期戦略」の目的は内部監査の法的環境の整備、内部監査人の実務能力の向上、専門的なレベルの内部監査を実施するためである。

2.2 戦略目的を達成するために以下の目標を設定する。



三. 戦略の実施に関して順守すべき原則

- 3.1 大蔵省は政府部門の内部監査中期戦略計画に反映された活動実施に当たって中央及び地方政府機関に対する技術指導を提供する。
- 3.2 戦略実施によって発生する費用については国及び地方の予算編成の際に入れる。
- 3.3 適正に執行する義務が各段階の公共部門の管理者、内部監査担当部署または被監査局に与えられている。
- 3.4 戦略の内容または方針に変更を入れる場合は各関係者が意見を出して公開的に議論し、解決する。

四. 戦略目標に掲げた活動の実施

- 4.1 内部監査の法的環境の整備：
 - 4.1.1 政府部門の内部監査法案の提出・承認。
 - 4.1.2 承認された内部監査法との整合性をとった内部監査の実施に必要な関連規定の作成・承認。
- 4.2 組織体制の改善（再編）
 - 4.2.1 内部監査法との整合性を取り、内部監査局、内部監査委員会の組織体制確立。
 - 4.2.2 内部監査人の採用、報告ライン制度の整備。

4.2.3 内部監査の総合情報データベースの作成、内部監査の総括的な指導ができるような環境の整備

4.3 内部監査人の実務能力の強化

4.3.1 政府部門の内部監査人を育成する総合的な研修プログラムを作成し、その内容に関しては、法規定に基づいて専門的な機関に依頼する部分と大蔵省が担当する部分を明確にする。

4.3.2 政府部門の内部監査の総合情報システムに内部監査人の研修参加情報を入力し、人事評価制度と連携させ、業績評価に反映させる。

4.3.3 研修及び内部監査実施に必要な資料、マニュアルの作成、IPPFの更新。これらを内部監査実務に使用し、改善を行う。

4.4 内部監査の品質向上

4.4.1 内部監査の品質管理に関する評価規則の作成、承認。

4.4.2 内部監査の品質管理に関する外部評価プログラムを作成し、作成された内部監査の外部評価マニュアルを使用して実施する。外部評価マニュアルの改善・更新を行う。

4.4.3 品質管理の情報データベースを作成し、内部監査に関する情報をまとめ、情報システムに入力された監査成果に対して品質管理を実施する制度を整備。

4.4.4 内部監査にかかる内部評価制度の整備、必要なマニュアルと資料の作成、内部監査の品質管理に関する内部評価の成果を人事評価に応用する仕組みをつくる。

政府部門における内部監査中期戦略の実施計画
(2017-2020 年)

1

目標	戦略	実施活動	担当機関	期間	予算
戦略目的1 法的環境の整備	戦略 1.1：内部監査法及び関連規定、ガイドラインの作成、承認	1.1.1 法案の提出・承認 1.1.2 法律の広報活動（全国的な）	MOF 法務省	2017年6月25日まで	法律の広報活動に約30人/月
	戦略 1.2：内部監査法に適合した業務実施規則類の整備	1.2.1 内部監査法との整合性を取り、内部監査規定の改正・承認 1.2.2 内部監査委員会規定の改正、承認			
	戦略 1.3：内部監査業務実施に必要な法規定の改善	1.3.1 内部監査人倫理規定の作成、承認 1.3.2 複数組織での共有内部監査部門を設置に係る調整手続きに関する規定策定と承認			
戦略目的2 組織体制の改善（再編）	戦略 2.1：内部監査部門の体制改善	2.1.1 内部監査及び業績モニタリング担当部署の組織体制の再編（内部監査業務と業績モニタリング業務を分ける） 2.1.2 内部監査部門の活動への支援	MOF 各省 予算総括管理者（大臣）		
	戦略 2.2：内部監査の独立性を図る	2.2.1 監査委員会の再編（内部監査法に基づき） 2.2.2 内部監査の報告ラインの構築 2.2.3 内部監査人の採用制度の整備 2.2.4 内部監査人の賄賂及び不正行為防止のために適正な報酬制度を整備		2017年6月25日まで	
	戦略 2.3：内部監査の総括的な指導制度の強化	2.3.1 中央および地方府の内部監査総合ネットワークの構築 2.3.2 全国の内部監査に関する情報データベースの構築	MOF	2017-2018年12月	サーバー、ネットワークの予算
戦略目的3 内部監査人の実務能力の向上	戦略 3.1：内部監査人の実務的能力向上制度の整備	3.1.1 継続研修計画の策定	MOF 各省 予算総括管理者（大臣）		
		3.1.2 政府部門内部監査人に対する専門的研修を実施する非政府機関を法律に基づいて選定する			
		3.1.3 内部監査人に対する内部監査研修の実施			

		3.1.4 幹部職員に対する研修の実施			
		3.1.5 内部監査指導士の研修実施			
		3.1.6 政府部門内部監査人に関するデータベースの構築			
		3.1.7 内部監査人の実務経験に関する意見交換会を定期的の実施			
		戦略 3.2 : マニュアル、教材	MOF	2017年6月	印刷費
	3.2.1 内部監査マニュアルの更新				
	3.2.2 政府部門内部監査の総合データベースの利用に関するマニュアルの作成、関連研修の実施				
	3.2.3 IPPF の最新版の翻訳、内部監査人への関連研修の実施			翻訳費、印刷費	
戦略目的 4 内部監査の質的な向上	戦略 4.1 : 品質管理に関する外部評価制度の構築	4.1.1 品質管理計画の策定・実施			
		4.1.2 外部評価マニュアルの作成、関連研修の実施			
	4.1.3 外部評価規定の作成・承認 4.1.4 外部評価情報の総括データベースへの挿入				
戦略 4.2 : 内部監査の内部評価制度の整備	4.2.1 品質管理に関する内部評価マニュアルの作成、研修の実施 4.2.2 内部評価規定の作成 4.2.3 内部評価計画の策定 4.2.4 内部評価結果と人事成績評価の連携制度の整備		2018年1月1日- 2018年12月31日		

